



ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ
СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН 2016 ОНЫ НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ



www.nso.mn govisumber.nso.mn www.1212.mn

1. ХҮН АМ, ӨРХ, НИЙГМИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

1.1. 2016 оны жилийн эцсийн байдлаар манай аймаг 16934 хүн, үүнээс эрэгтэй 8476, эмэгтэй 8458 хүнтэй боллоо. Өмнөх оны мөн үетэй харьцуулбал хүн ам 626 буюу 3.8 хувиар, үүнээс эрэгтэй 230 буюу 2.8 хувиар, эмэгтэй 396 буюу 4.9 хувиар өссөн үзүүлэлттэй гарлаа. Нийт хүн амын 50.1 хувийг эрэгтэйчүүд, 49.9 хувийг эмэгтэйчүүд эзэлж байна.

Нийт хүн амын 33.8 хувийг 0-15 насны хүүхэд, 60.7 хувийг 16-59 насны хүмүүс, 5.5 хувийг 60 ба түүнээс дээш насны хүмүүс эзэлж байна. Насны бүлгээс харахад 70 ба түүнээс дээш настан 366, 80 ба түүнээс дээш настан 99, 90 ба түүнээс дээш настан 16 тоологдлоо. Дээрх үзүүлэлтийг өмнөх оны мөн үетэй харьцуулбал 70 ба түүнээс дээш настан 2.7 хувиар, 80 ба түүнээс дээш настан 1.0 хувиар, 90 ба түүнээс дээш настан 11.1 хувиар тус тус буурсан байна.

Манай аймгийн иргэдээс гадаадад 6 ба түүнээс дээш сарын хугацаагаар оршин суугаа 156 иргэн бүртгэгдсэн бөгөөд тэдгээрийн 77 буюу 49.4 хувь нь эрэгтэйчүүд, 79 буюу 50.6 хувь нь эмэгтэйчүүд байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулбал гадаадад суугаа иргэд 12.2 хувиар, үүнээс эрэгтэйчүүд 16.7 хувиар, эмэгтэйчүүд 8.2 хувиар тус тус өссөн үзүүлэлт гарлаа.

Тайлант онд 5189 өрх тоологдсон нь өмнөх оноос 202 өрхөөр буюу 4.1 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Нийт өрхөөс 3048 буюу 58.7 хувь нь аймгийн төвд, 921 буюу 17.7 хувь нь сумын төвд, 1220 өрх буюу 23.5 хувь нь хөдөөд байршиж байгаа бөгөөд нийт өрхөөс 10 буюу түүнээс дээш ам бүлтэй өрх 12 тоологдлоо.

1.2. 2016 онд хөдөлмөрийн насны хүн ам 10272, үүнээс 5869 нь ажиллагчид байгаа нь хөдөлмөрийн насны хүн амын 57.1 хувийг эзэлж байна. Аймгийн хэмжээнд нийт 5988 хүн хөдөлмөр эрхэлж байгаагаас 2 хувь нь тэтгэврийн насны хүмүүс байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулбал хөдөлмөрийн насны хүн ам 2.8 хувиар, хөдөлмөрийн насны ажил эрхлэгч 0.7 хувиар өссөн үзүүлэлт гарчээ.

Хөдөлмөр, халамж, үйлчилгээний газарт бүртгүүлсэн ажил хайгч ажилгүй иргэдийн тоо 2016 оны 12 сард 238 байгаагийн 130 нь эмэгтэйчүүд байна. Ажил хайгч ажилгүй иргэдийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 94 буюу 71.7 хувиар, 151 ажлын байрны захиалга ирсэн нь өмнөх оны мөн үеэс 3.5 дахин, 49 иргэн ажилд зуучлуулсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 6.1 дахин буурсан байна. Ажилд зуучлагдсан иргэдийн 29 буюу 59.2 хувь нь эмэгтэйчүүд байлаа.

Тайлант онд Хөдөлмөр, халамж, үйлчилгээний газраас давхардсан тоогоор 4724 хүнд 1259.7 сая төгрөгийн тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлт, халамж үйлчилгээ үзүүлсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад үйлчилгээ авсан иргэдийн тоо 216 буюу 4.8 хувиар, олгосон тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлтийн хэмжээ 34.4 сая төгрөг буюу 2.8 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна.

1.3. 2016 оны жилийн эцсийн байдлаар иргэний бүртгэлийн мэдээгээр аймгийн хэмжээнд 459 эхээс 465 хүүхэд мэндэлсний 244 нь хүү, 221 нь охин байлаа. Нийт 115 хүн нас барсан байна. Бүртгүүлсэн гэр бүл 81, цуцалсан гэр бүл 20, үрчлэгдсэн хүүхэд 7 бүртгэгдлээ. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад төрөлт 24 буюу 5.5 хувиар, төрсөн хүүхэд 24 буюу 5.4

хувиар, нас баралт 25 буюу 27.8 хувиар, бүртгүүлсэн гэр бүл 3 буюу 3.8 хувиар тус тус өссөн бол цуцалсан гэр бүл 4 буюу 16.7 хувиар буурч, үрчлэгдсэн хүүхэд өмнөх оны мөн үетэй ижил түвшинд байна.

Шилжин ирсэн хүн 745 байгаа нь өмнөх оны мөн үеэс 54 хүн буюу 6.8 хувиар буурч, шилжин явсан хүн 687 болж өмнөх оны мөн үеэс 10 хүн буюу 1.5 хувиар өссөн байна. Шилжин ирэгсдийн 354 буюу 47.5 хувь нь Улаанбаатар хотоос, 118 буюу 15.8 хувь нь Дундговь аймгаас, 113 буюу 15.2 хувь нь Дорноговь аймгаас, 160 буюу 21.5 хувь нь бусад аймгаас ирсэн байна. Шилжин явагчдын 384 буюу 55.9 хувь нь Улаанбаатар хот руу, 98 буюу 14.3 хувь нь Дорноговь аймаг руу, 48 буюу 7.0 хувь нь Дундговь аймаг руу, 157 буюу 22.8 хувь нь бусад аймаг руу шилжин явсан байна.

1.4. Багуудаас гаргасан мэдээллээр аймгийн хэмжээнд бүтэн өнчин хүүхэд 24, үүнээс эмэгтэй 9, хагас өнчин хүүхэд 185, үүнээс эмэгтэй 73 байгаа нь өмнөх оны мөн үеэс бүтэн өнчин хүүхэд 1 буюу 4.3 хувиар, хагас өнчин хүүхэд 8 буюу 4.5 хувиар өссөн байна. Өрх толгойлсон эцэг, эх 779 бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 34 буюу 4.6 хувиар өссөн байна. Ганц бие өндөр настан 277 байгаа нь өмнөх оны мөн үеэс 6 буюу 2.2 хувиар, хөгжлийн бэрхшээлтэй иргэд 683 байгаа нь өмнөх оны мөн үеэс 14 буюу 2.1 хувиар тус тус өсжээ.

Хүн амын амьжиргааны доод түвшнээс доогуур орлоготой өрхийн зарим үзүүлэлтүүдийг тайлант оны байдлаар авч үзвэл (Тайлант онд амьжиргааны доод түвшин төвийн бүсэд 163000 төгрөг байлаа.)

Ядуу өрх 378, өрхийн гишүүд 1615 байгаа нь нийт өрхийн 6.9 хувийг, нийт хүн амын 9.1 хувийг эзэлж байгаа бөгөөд өрх болон хүн амд эзлэх хувийг өмнөх оны мөн үетэй харьцуулбал 0.3-0.4 пунктээр буурсан үзүүлэлт гарлаа.

Ядуу өрхийг ам бүлээр нь танилцуулбал нэг ам бүлтэй 32 өрх, 2-5 ам бүлтэй 250 өрх, 6 ба түүнээс дээш ам бүлтэй 96 өрх, өрхийн гишүүдийг насны бүлгээр танилцуулбал 0-7 насны 329 хүүхэд, 8-15 насны 338 хүүхэд, 16-59 насны 883 хүн, 60 ба түүнээс дээш насны 65 хүн бүртгэгдсэн байна.

2. МАЛ ТООЛЛОГО, ХӨДӨӨ АЖ АХУЙ

2.1. 2016 оны жилийн эцсийн мал тооллогын дүнгээр аймгийн хэмжээнд 1055 малтай өрх тоологдсоноос 721 малчин өрх, 334 малтай өрх / тавиул малтай өрх 1/ тоологдлоо. Малчин өрхөд 2449 хүн амьдарч байгаагаас 1231 малчин, үүнээс 558 нь эмэгтэй малчид байна.

Нийт малчдыг насны бүлгээр нь авч үзвэл :

15-34 нас - 338 малчин буюу 27.5 хувь

35-59 нас- 740 малчин буюу 60.1 хувь

60 аас дээш нас - 153 малчин буюу 12.4 хувийг тус тус эзэлж байна.

Өмнөх оны мөн үетэй харьцуулбал малтай өрх 60 буюу 6.0 хувиар, малчин өрх 48 буюу 7.1 хувиар, мал бүхий өрх 12 буюу 3.7 хувиар тус тус нэмэгдсэн байна. Малчдын тоог өмнөх оны мөн үетэй харьцуулбал 71 буюу 6.1 хувиар үүнээс эмэгтэй малчид 23 буюу 4.3 хувиар өслөө.

Энэ онд манай аймагт нэг мянгаас дээш толгой мал тоолуулсан 90 малтай иргэн бүртгэгдсэнээс 88 нь малчин байгаа нь өмнөх оны мөн үеэс 6 буюу 6.4 хувиар буурлаа. Үүнд:

Сүмбэр сумын мянгат малчин	63
Баянтал сумын мянгат малчин	15
Шивээговь сумын мянгат малчин	10

Мянгат малчдаас:

Хамгийн их малтай нь Сүмбэр сумын 5 дугаар багийн малчин Д.Зоригтсайхан /3177 толгой /,
Хамгийн их адуутай нь Баянтал сумын 2 дугаар багийн малчин Л.Батнасан /392 толгой/,
Хамгийн их үхэртэй нь Сүмбэр сумын 4 дүгээр багийн малчин М.Батсайхан /315 толгой /,
Хамгийн их тэмээтэй нь Сүмбэр сумын 6 дугаар багийн малчин Б.Болдбаатар /93 толгой /,
Хамгийн их хоньтой нь Баянтал сумын 2 дугаар багийн малчин А.Замзаах /1865 толгой/,
Хамгийн их ямаатай нь Сүмбэр сумын 6 дугаар багийн малчин Б.Болдбаатар /1174 толгой/ нар байлаа.

	Малтай өрхийн малын бүлэглэлт	Малчин өрхийн малын бүлэглэлт
10 хүртэл толгой малтай	26	5
11-30 толгой малтай	80	25
31-50 толгой малтай	62	22
51-100 толгой малтай	138	59
101-200 толгой малтай	167	104
201-500 толгой малтай	313	246
501-999 толгой малтай	179	172
1000-1499 толгой малтай	68	67
1500-2000 толгой малтай	11	11
2001 түүнээс дээш толгой малтай	11	10

2.2. 2016 оны жилийн эцсээр манай аймаг 397.9 мянган толгой малтай болсон нь өмнөх оны мөн үеэс 18.4 мянган толгой буюу 4.9 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Үүнээс: адуу 20250 толгой, үхэр 13646 толгой, тэмээ 822 толгой, хонь 185883 толгой, ямаа 177309 толгой тус тус тоологджээ. Аймгийн хэмжээнд төллөвөл зохих эх малын 91.8 хувь буюу 157213 толгой мал төллөж, гарсан төл 160374, үүнээс 7308 төл хорогдож, 153066 төл бойжиж төл бойжилт 95.4 хувьтай гарлаа. Оны эцэст 185.9 мянган толгой хээлтэгч мал байгаа нь өмнөх оны мөн үеэс 14.4 толгой буюу 8.4 хувиар өсчээ.

2015 онд 4061 төл хорогдсон бол 2016 онд 7308 төл хорогдож өмнөх оны мөн үеэс 3247 буюу 80.0 хувиар өссөн ба нийт хорогдсон төлийн 59.3 хувийг ишиг, 37.2 хувийг хурга эзэлж байна. Жилийн эцсийн байдлаар 14686 том мал зүй бусаар хорогдсон нь өмнөх оны мөн үеэс 12.7 мянга буюу 7.4 дахин өссөн байна.

2.3. Эрлийз, цэвэр үүлдэр, сайжруулсан омгийн мал 13737, үүнээс “Сүмбэр” хонь 1591 толгой тоологдлоо. Энэ нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал эрлийз, цэвэр үүлдрийн мал 39.8 хувиар, “Сүмбэр” хонь 19.3 хувиар тус тус өссөн байна. Нийт малд эрлийз, цэвэр үүлдэр, сайжруулсан омгийн мал 3.5 хувийг эзэлж байгаа бол эрлийз, цэвэр үүлдэр, сайжруулсан

омгийн адуу 124 тоологдсон нь нийт адууны 0.6 хувийг, эрлийз, цэвэр үүлдэр, сайжруулсан омгийн үхэр 632 тоологдсон нь нийт үхрийн 4.6 хувийг, эрлийз, цэвэр үүлдэр, сайжруулсан омгийн тэмээ 68 тоологдсон нь нийт тэмээний 8.3 хувийг, эрлийз, цэвэр үүлдэр, сайжруулсан омгийн хонь 8417 тоологдсон нь нийт хонины 4.5 хувийг, эрлийз, цэвэр үүлдэр, сайжруулсан омгийн ямаа 4496 тоологдсон нь нийт ямааны 2.5 хувийг тус тус эзэлж байна.

2.4. Хүн ам, мал, хөдөө аж ахуйн тэжээвэр амьтдын 2016 оны тооллогоор аймгийн дүнгээр гахай, тахиа, туулай 4074 тоологдсон нь өмнөх оны мөн үеэс 23.3 хувиар өссөн үзүүлэлт гарлаа.

Нийт 277 гахай үүнээс:

Хээлтэгч	109	
Хээлтүүлэгч	30	
Бусад		138

Нийт 3793 тахиа үүнээс:

Үндсэн эх	138	
Хээлтүүлэгч	35	
Бусад		3620

Өмнөх оны мөн үетэй харьцуулахад гахай 66 буюу 19.2 хувиар цөөрч, тахиа 837 буюу 28.3 хувиар өссөн байна.

2.5 2016 онд 51.7 га талбайд тариалалт хийснээс төмс 22.9 га-д, хүнсний ногоо 18.2 га-д, тэжээлийн ургамал 10.6 га-д тариалсан байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулбал нийт тариалсан талбай 25.8 га буюу 2 дахин их байгаагаас төмсний талбай 14.6 га буюу 2.8 дахин, хүнсний ногооны талбай 2 га буюу 12.3 хувиар, тэжээлийн ургамлын талбай 9.2 га буюу 7.6 дахин нэмэгдсэн байна.

Ургац хураалтын эцсийн мэдээгээр аймгийн хэмжээнд 97.7 тн төмс, 117.4 тн хүнсний ногоо, 5.1 тн тэжээлийн ургамал хурааж авсан нь өмнөх оны мөн үеэс 64.7 тн-оор буюу 41.6 хувиар, үүнээс төмс 48.3 тн буюу 2 дахин, хүнсний ногоо 14.3 тн буюу 13.9 хувиар, тэжээлийн ургамал 2.1 тн буюу 70.0 хувиар тус тус өссөн байна.

2016 онд малчид 1672.3 тн өвс, 0.2 тн дарш, 316.9 тн хужир шүү бэлтгэж авсныг өмнөх оны мөн үетэй харьцуулбал бэлтгэсэн өвс 5.8 хувиар буурч, бэлтгэсэн хужир 7.9 хувиар нэмэгдсэн байна.

3. АЖ ҮЙЛДВЭР

3.1 Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлтийн мэдээг “Шивээ-Овоо” ХК, “Ус-Ду” ОНӨААТҮГ, “Тохижилт Сүмбэр” ОНӨААТҮГ, “Талын илч” ОНӨААТҮГ, “Илчлэг Шивээ” ОНӨААТҮГ, “Илчит сансар” ХХК зэрэг аж ахуйн нэгж байгууллагуудаас авдаг бөгөөд эдгээр аж ахуйн нэгж байгууллагууд 2016

онд 47.1 тэр бум төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, 44.7 тэр бум төгрөгийн бүтээгдэхүүн борлуулсан байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулбал бүтээгдэхүүн үйлдвэрлэлт 25.3 хувиар

өссөн ба үүнд уул, уурхайн салбарын үйлдвэрлэлт голлон нөлөөлсөн байна. Бүтээгдэхүүн борлуулалт өмнөх оны мөн үеэс 14.5 хувиар өслөө.

“Шивээ-Овоо” ХК нь тайлант онд 45.1 тэр бум төгрөгийн нүүрс үйлдвэрлэж, 42.8 тэр бум төгрөгийн борлуулалт хийсэн байна. Эдгээр үзүүлэлтийг өмнөх оны мөн үетэй харьцуулбал бүтээгдэхүүн үйлдвэрлэлт 26.4 хувиар, бүтээгдэхүүн борлуулалт 15.0 хувиар өссөн үзүүлэлттэй гарлаа. Тус компани нь аймгийн нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн 95.9 хувийг, нийт борлуулалтын 95.6 хувийг гүйцэтгэсэн бөгөөд зах зээл дээр 1 тонн нүүрсийг 26642 төгрөгөөр худалдаалж байна.

3.2 Аймгийн хэмжээний төв суурин газруудад халаалт, халуун хүйтэн ус үйлдвэрлэх, бохир ус татан зайлуулах чиглэлээр Ус-Ду, Талын Илч, Илчлэг Шивээ, Илчит сансар зэрэг аж ахуйн нэгжүүд үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд 2016 онд нийт 1952.5 сая төгрөгийн үйлдвэрлэл явуулснаас 1689.1 сая төгрөгийн дулаан, 186.0 сая төгрөгийн ус, 77.3 сая төгрөгийн татан зайлуулсан бохир ус хийсэн байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулбал нийт үйлдвэрлэл 5.0 хувиар үүнээс дулаан үйлдвэрлэл 4.0 хувиар, ус 10.2 хувиар, сувагжуулалт 15.3 хувиар тус тус нэмэгдлээ.

4. ТӨСӨВ САНХҮҮ, БАНК, ОРОН НУТГИЙН ӨМЧ

4.1 2016 оны байдлаар орон нутгийн төсвийн нийт орлогын төлөвлөгөө 15036.3 сая төгрөг, гүйцэтгэл 15701.4 сая төгрөг болж орлогын төлөвлөгөө 104.4 хувийн биелэлттэй байна. Төсвийн орлогыг задаргаагаар нь авч үзвэл хөрөнгийн орлого 47.5 хувиар, урсгал орлого 13.2 хувиар тус тус даван биелэсэн үзүүлэлт гарлаа.

Оны эцсийн байдлаар төсвийн зарлага аймгийн хэмжээгээр 16828.0 сая төгрөг төлөвлөгдсөнөөс 14687.0 сая төгрөгийн гүйцэтгэлтэй 2141.0 сая төгрөг буюу 12.3 хувийн хэмнэлттэй гарлаа. Нийт зардлыг задаргаагаар нь авч үзвэл хөрөнгийн зардал 21.8 хувийн, урсгал орлого 10.1 хувийн хэмнэлттэй гарсан байна.

Төсөвт байгууллагын өглөг, авлагын мэдээгээр өглөгийн үлдэгдэл 27.9 сая төгрөг, авлагын үлдэгдэл 12.3 сая төгрөг болсон нь өмнөх оны мөн үеэс өглөг 10.8 дахин, авлага 32.4 дахин буурсан үзүүлэлттэй байна.

4.2. Говьсүмбэр аймагт үйл ажиллагаа явуулж буй банкуудын салбарын эдийн засгийн үзүүлэлтийг 2016 оны эцсийн байдлаар танилцуулбал цахим банкны үйлчилгээ хэрэглэгчид 22.1 мянгад хүрч өмнөх оны мөн үеэс 29.5 хувиар, зээл авсан малчдын тоо 49.6 хувиар, малчдад олгосон зээлийн хэмжээ 2.9 дахин, иргэдэд олгосон зээлийн хэмжээ 2 дахин өссөн бөгөөд АТМ-н тоо 22.2 хувиар нэмэгдэж, салбар үйлчилгээний цэг 21.4 хувиар, зээлийн бүтээгдэхүүн 31.6 хувиар, зээл авсан аж ахуйн нэгж 35.5 хувиар, иргэд 2.6 хувиар буурсан байна.

4.3. Орон нутгийн өмчийн газрын мэдээгээр манай аймаг 2016 онд Улсын төсвийн болон аймаг, сумдын орон нутгийн хөгжил сангийн хөрөнгөөр нийт 51 төсөл, арга хэмжээг 2066.9 сая төгрөгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 1832.5 төгрөгийн төсөл, арга хэмжээ гэрээлэгдсэн байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулбал төлөвлөгдсөн бараа, ажил үйлчилгээ

28.2 хувиар, төсөв 45.7 хувиар тус тус буурсан үзүүлэлт гарлаа. Өмнөх онд төлөвлөсөн бараа үйлчилгээний 83.1 хувь нь зарлагдаж, төлөвлөсөн төсвийн 69.7 хувь нь гэрээлэгдсэн бол тайлант онд төлөвлөсөн бараа үйлчилгээ 100 хувь зарлагдаж, төлөвлөсөн төсвийн 88.7 хувь нь гэрээлэгдсэн байна.

5. НИЙГМИЙН ДААТГАЛ, БУСАД ДААТГАЛУУД

5.1 Нийгмийн даатгалын сангийн орлого 2016 оны байдлаар 7583.6 сая төгрөг, зарлага 9385.3 сая төгрөг болж, өмнөх оны мөн үеэс орлого 898.5 сая төгрөг буюу 13.4 хувиар, зарлага 784.7 сая төгрөг буюу 9.1 хувиар тус тус өслөө.

Нийгмийн даатгалын сангийн орлого нэмэгдэхэд тэтгэврийн даатгалын сангийн орлого 7.0 хувиар, тэтгэмжийн даатгалын сангийн орлого 23.8 хувиар, эрүүл мэндийн даатгалын сангийн орлого 20.1 хувиар өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Нийгмийн даатгалын сангийн зарлага өсөхөд тэтгэврийн сангийн зарлага 10.3 хувиар, эрүүл мэндийн даатгалын сангийн зарлага 13.2 хувиар, ажилгүйдлийн даатгалын сангийн зарлага 9.3 хувиар өссөн нь голлон нөлөөлөв.

5.2 Говьсүмбэр аймагт үйл ажиллагаа явуулдаг даатгалын компаниудын тайлант оны мэдээллээс танилцуулахад нийт орлого 212.2 сая төгрөг, олгосон нөхөн төлбөр 68.8 сая төгрөгт хүрснийг өмнөх оны мөн үетэй харьцуулбал орлого 4 хувиар нэмэгдэж, олгосон нөхөн төлбөр 22.8 хувиар буурсан байна. Орлого нэмэгдэхэд хүүхдийн гэнэтийн ослын даатгалын орлого эрс нэмэгдсэн нь нөлөөлсөн бол олгосон нөхөн төлбөр буурсан нь эд хөрөнгийн болон эрүүл мэндийн даатгалын нөхөн төлбөр огцом буурсан нь нөлөөлжээ. Тайлант оны хувьд тээврийн хэрэгслийн даатгалын нөхөн төлөлт, мэргэжлийн хариуцлагын даатгалын нөхөн төлөлтүүд нь орлогоосоо давсан үзүүлэлттэй байна.

6. ТЭЭВЭР, ХОЛБОО, ГАЗАР

6.1 Авто тээврийн үндэсний төвийн Говьсүмбэр аймаг дахь салбарын мэдээгээр тайлант онд 23.7 мянган зорчигч тээвэрлэж, зорчигч эргэлт 5355.2 мян.хүн км болж, 11 ажилтантай 14.2 сая төгрөгийн орлоготой ажилласан байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулбал зорчигч тээвэрлэлт 8.0 хувиар, зорчигч эргэлт 1.0 хувиар, тээврийн орлого 17.2 хувиар тус тус өссөн үзүүлэлт гарлаа.

2016 оны байдлаар 3047 тээврийн хэрэгсэл бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 11.7 хувиар буурсан байна. Тээврийн хэрэгслийг төрлөөр нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал суудлын авто машин 2.3 хувиар, ачааны автомашин 11.3 хувиар, 2 дугуйт 2.5 хувиар өссөн хэдий ч бусад төрлийн тээврийн хэрэгсэл 3 дахин буурсан үзүүлэлттэй байна.

6.2 Аймгийн холбооны газрын мэдээгээр 2016 онд нийт орлого 202.4 сая төгрөг болж өмнөх оны мөн үеэс 17.7 сая төг буюу 8.0 хувиар буурчээ. Нийт орлогод хүн амаас орсон орлого 121.6 сая төг буюу 60.0 хувийг эзэлж, өмнөх оны мөн үетэй ижил түвшинд байна. Аймгийн хэмжээнд нийт суурин телефон цэгийн тоо 334 болж өмнөх оны мөн үеэс 64 буюу

16.1 хувиар, КТВ суваг 1233 болж өмнөх оны мөн үеэс 39 буюу 3.1 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

2016 онд интернет үйлчилгээний цэгийн тоо 1 байгаа нь өмнөх оны мөн үеэс 2 дахин багассан үзүүлэлттэй байна. Интернет үйлчилгээний цэгээр үйлчлүүлэгчийн тоо 270 үүнээс байнгын хэрэглэгчийн тоо 77 байна. Тайлант онд 35 цахилгаан мэдээ гарсан нь өмнөх оны мөн үеэс 39.7 хувиар буурсан байна.

6.3 Газрын харилцаа, Барилга хот байгуулалтын газрын мэдээгээр манай аймгийн нийт газар нутгийн хэмжээ 554.2 мян.га байдаг бөгөөд нийт талбайн:

376819 га буюу 68.0 хувийг Сүмбэр сум

91606 га буюу 16.5 хувийг Баянтал сум

85755 га буюу 15.5 хувийг Шивээговь сум эзэлж байна.

2016 онд нийт газрын:

481694.0 га буюу 86.9 хувийг - Хөдөө аж ахуйн газар

6168.6 га буюу 1.1 хувийг - Хот, тосгон, суурин газар

5117.6 га буюу 0.9 хувийг - Зам шугам сүлжээний газар

1538.0 га буюу 0.3 хувийг - Усны сан бүхий газар

59661.8 га буюу 10.8 хувийг -Улсын тусгай хэрэгцээний

газар тус тус эзэлж байна. Эдгээр газрыг өмнөх оны мөн үетэй харьцуулбал хөдөө аж ахуйн газар 0.03 хувиар багасч, хот, тосгон суурин газар 2.2 хувиар, зам, шугам сүлжээний газар 0.07 хувиар нэмэгдсэн байна.

Тайлант жилд нийт газрын 0.9 хувьд хохирол учирсан байна. Газарт учирсан хохирлыг ангилж үзвэл 94.2 хувь нь бэлчээр ба бусад суурин газар, 5.0 хувь нь хот тосгон бусад суурин газар, 0.7 хувь нь усны сан бүхий газар, 0.1 хувь нь ухаж эвдэрсэн газар тус тус эзэлж байгааг өмнөх оны мөн үетэй харьцуулбал хохирол учирсан нийт талбай 0.9 пунктээр, бэлчээр ба бусад суурин газар 0.6 пунктээр, ухаж эвдэрсэн газар 0.2 пунктээр буурч, хот тосгон бусад суурин газар болон усны сан бүхий газар 0.4 пунктээр өссөн үзүүлэлт гарлаа.

2016 онд нийт газар нутгийн 0.06 хувь буюу 338.9 га талбайд газар хамгаалах арга хэмжээ авсан нь өмнөх оны мөн үеэс 0.02 пунктээр буурсан байна. Газрын төлбөр төлөлт, ноогдуулалтанд 119.7 сая төгрөгийн төлбөр төлөгдсөн нь өмнөх оны мөн үеэс 24.6 хувиар өссөн үзүүлэлттэй гарлаа.

Нийт газар өмчлөгч иргэдийг өссөн дүнгээр танилцуулбал 7044 байгааг жилийн эцсийн хүн амтай харьцуулбал 41.6 хувийг эзэлж байна.

7. БОЛОВСРОЛ

7.1 2016-2017 оны хичээлийн жилийн байдлаар аймгийн хэмжээнд төрийн өмчийн 5 цэцэрлэг, хувийн өмчийн 4 цэцэрлэг нийт 9 цэцэрлэгийн 49 бүлэгт 1652 хүүхэд байгаагаас эмэгтэй 797 хүүхэд хамрагдан хүмүүжиж байна. Цэцэрлэгт хамрагдаж буй хүүхдийн 151 буюу 9.1 нь малчдын хүүхэд байна. Цэцэрлэгийн бүлгийг тоогоор нь авч үзвэл бага бүлэг 12, дунд бүлэг 10, ахлах бүлэг 8, бэлтгэл бүлэг 10, холимог бүлэг 3, ээлжийн бүлэг 1, нүүдлийн бүлэг 5 байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулбал бүлгийн тоо ижил түвшинд, хамрагдсан хүүхэд 4.2 хувиар, үүнээс эмэгтэй хүүхэд 5.4 хувиар өсч, харин малчдын хүүхэд 24.1 хувиар буурсан үзүүлэлт гарлаа.

Сургуулийн өмнөх боловсролын байгууллагад 161 ажиллагсад байгаагаас 149 буюу 88.2 хувь нь эмэгтэй ажиллагсад байгааг өмнөх оны мөн үетэй харьцуулбал нийт ажиллагсад 0.6 хувиар, эмэгтэй ажиллагсад 4.7 хувиар тус тус буурсан байна. Нийт ажиллагсдаас эрхлэгч, арга зүйч, эмчийн тоо өмнөх оны мөн үетэй ижил түвшинд, үндсэн болон туслах багшийн тоо 2.2-2.4 хувиар нэмэгджээ.

7.2 2016-2017 оны хичээлийн жилд ерөнхий боловсролын 5 сургуулийн 122 бүлэгт 3340 сурагч суралцаж байгаагаас I-V ангид 1740 сурагч, VI-IX ангид 1026, X-XII ангид 574 сурагч байна. ЕБС-д хөгжлийн бэрхшээлтэй 28 сурагч суралцаж, дотуур байранд 165 сурагч амьдарч байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулбал бүлгийн тоо 0.8 хувиар, суралцагчид 1.2 хувиар, хөгжлийн бэрхшээлтэй суралцагч 7.7 хувиар, дотуур байранд амьдарч буй суралцагч 22.2 хувиар тус тус нэмэгдсэн байна.

2016-2017 оны хичээлийн жилд 369 хүүхэд 1-р ангид элсэн орсон байна. Насны ангиллаар нь авч үзвэл 5 настай 3, 6 настай 355, 7 настай 9 хүүхэд байлаа. ЕБС-д 275 ажиллагсад үүнээс 223 буюу 81.1 хувь нь эмэгтэй байгааг өмнөх оны мөн үетэй харьцуулбал нийт ажиллагсад 0.7 хувиар, эмэгтэй ажиллагсад 0.5 хувиар тус тус нэмэгдсэн байна. 181 үндсэн багш ажиллаж байгаа ба нэг багшид ногдох суралцагчийн тоо 18.5 байгаа нь өмнөх оны мөн үеэс 0.1 пунктээр нэмэгдсэн байна. Үндсэн багш болон бусад ажиллагсад 1.1-1.4 хувиар нэмэгдэж, нийгмийн ажилтан 20.0 хувиар цөөрсөн үзүүлэлт гарлаа.

8. ЭРҮҮЛ МЭНД

Эрүүл мэндийн мэдээгээр 2016 онд 446 эх амаржиж, 2015 оны мөн үетэй харьцуулахад 4 буюу 0.9 хувиар нэмэгдсэн байна. Амьд төрсөн хүүхэд 450 үүнээс 222 нь хүү, 228 нь охин байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулбал амьд төрсөн хүүхэд 4 буюу 0.9 хувиар өсчээ. 0-1 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 7 ба 1000 амьд төрөлтөд 16, 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 9 ба 1000 амьд төрөлтөд 20 хүүхэд тус тус ногдож байна. Эхийн эндэгдэл бүртгэгдээгүй болно.

Он гарсаар 122.1 мянган хүнд амбулаторийн үзлэг хийсэн нь өмнөх оны мөн үеэс 1.9 хувиар, 5.0 мянган хүн эмнэлэгт хэвтэж эмчлүүлсэн нь өмнөх оны мөн үеэс 10.0 хувиар өссөн байна. Халдварт өвчнөөр өвчлөгсөд 292 бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 2.5 дахин өслөө.

9. ГЭМТ ХЭРЭГ

Тайлант онд аймгийн хэмжээнд 207 гэмт хэрэг бүртгэгдсэн ба үйлдэгдсэн гэмт хэргийн 91 буюу 44.0 хувь нь хүний амь бие эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг байлаа . Бүртгэгдсэн гэмт хэрэг өмнөх оны мөн үеэс 1.9 хувиар буурсан байна. Гэмт хэрэгт холбогдогсод 218, үүний 96 буюу 44.0 хувь нь ажилгүй иргэдийн үйлдсэн гэмт хэрэг байна. Гэмт хэрэгт холбогдогсдыг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2.2 хувиар буурсан байна.

Давхардсан тоогоор 877 иргэнийг эрүүлжүүлж, 16 иргэнийг албадан болон сайн дурын эмчилгээнд хамруулсан нь өмнөх оны мөн үеэс эрүүлжүүлсэн иргэний тоо 23.7 хувиар буурч, албадан болон сайн дурын эмчилгээнд хамруулсан иргэний тоо 14.0 хувиар өсчээ.

Гэмт хэрэг илрүүлэлт жилийн эцсийн байдлаар 76.5 хувьтай байгаа нь өмнөх оны мөн үеэс 2.3 пунктээр буурсан байна. Гэмт хэргээс учирсан хохирол 472.0 сая төгрөг, нөхөн төлүүлсэн хохирол 306.0 сая төгрөгт хүрсэн байна.

ХАВСРАЛТ

Хүснэгт 1.1

Хүн ам, сумдаар, хүйсээр, харьцуулсан үзүүлэлтээр

Сумд		2015 он	2016 он	Өөрчлөлт	Хувь
Баянтал	Нийт хүн ам	1153	1204	51	104.4
	Эрэгтэй	585	606	21	103.6
	Эмэгтэй	568	598	30	105.3
Сүмбэр	Нийт хүн ам	11901	12352	451	103.8
	Эрэгтэй	5974	6125	151	102.5
	Эмэгтэй	5927	6227	300	105.1
Шивээговь	Нийт хүн ам	3254	3378	124	103.8
	Эрэгтэй	1687	1745	58	103.4
	Эмэгтэй	1567	1633	66	104.2
Бүгд	Нийт хүн ам	16308	16934	626	103.8
	Эрэгтэй	8246	8476	230	102.8
	Эмэгтэй	8062	8458	396	104.9

Хүснэгт 1.2

Хүн ам, насны бүлгээр, сумдаар, 2016 оны жилийн эцсийн байдлаар

Насны бүлэг	Аймгийн дүн	Сумд		
		Баянтал	Сүмбэр	Шивээговь
0-4.	2343	182	1672	489
5-9.	1850	120	1338	392
10-14.	1295	94	962	239
15-19	1331	94	980	257
20-24	1358	96	1011	251
25-29	1669	119	1179	371
30-34	1441	89	1042	310
35-39	1217	93	867	257
40-44	1130	84	844	202
45-49	954	62	698	194
50-54	826	53	613	160
55-59	595	56	426	113
60-64	344	27	258	59
65-69	215	16	165	34
70-74	144	5	110	29
75-79	123	9	100	14
80-84	63	5	53	5
85-89	20	0	19	1
90-94	16	0	15	1
Нийт	16934	1204	12352	3378

Гадаадад оршин суугаа иргэд, сумдаар, хүйсээр, харьцуулсан үзүүлэлтээр

Сумд		2015 он	2016 он	Өөрчлөлт	Хувь
	Нийт хүн ам	3	16	13	533.3
Баянтал	Эрэгтэй	1	8	7	800.0
	Эмэгтэй	2	8	6	400.0
	Нийт хүн ам	122	123	1	100.8
Сүмбэр	Эрэгтэй	57	60	3	105.3
	Эмэгтэй	65	63	-2	96.9
	Нийт хүн ам	14	17	3	121.4
Шивээговь	Эрэгтэй	8	9	1	112.5
	Эмэгтэй	6	8	2	133.3
	Нийт хүн ам	139	156	17	112.2
Бүгд	Эрэгтэй	66	77	11	116.7
	Эмэгтэй	73	79	6	108.2

Өрх, сумдаар, харьцуулсан үзүүлэлтээр

Сумд	Нийт өрх				10, түүнээс дээш ам бүлтэй өрх			
	2015 он	2016 он	Өөрчлөлт	Хувь	2015 он	2016 он	Өөрчлөлт	Хувь
Баянтал	361	387	26	107.2	0	0	0	0.0
Сүмбэр	3605	3754	149	104.1	13	12	-1	92.3
Шивээговь	1021	1048	27	102.6	1	0	-1	0.0
Бүгд	4987	5189	202	104.1	14	12	-2	85.7

Хөдөлмөрийн насны хүн ам, сумдаар, харьцуулсан үзүүлэлтээр

Сумд	Хөдөлмөрийн насны хүн ам				Хөдөлмөрийн насны ажиллагчид			
	2015 он	2016 он	Өөрчлөлт	Хувь	2015 он	2016 он	Өөрчлөлт	Хувь
Баянтал	703	727	24	103.4	462	534	72	115.6
Сүмбэр	7279	7472	193	102.7	4048	4058	10	100.2
Шивээговь	2011	2073	62	103.1	1286	1277	-9	99.3
Дүн	9993	10272	279	102.8	5796	5869	73	101.3

Хүснэгт 1.6

Ажил хайгч иргэд, харьцуулсан үзүүлэлтээр

Үзүүлэлтүүд	2015 он	2016 он	Өөрчлөлт	Хувь
Ажил хайгч иргэд	332	238	-94	71.7
Үүнээс эмэгтэй	187	130	-57	69.5
Ажлын байрны захиалга	535	151	-384	28.2
Ажилд зуучлагдсан иргэд	300	49	-251	16.3
Үүнээс эмэгтэй	171	29	-142	17.0

Хүснэгт 1.7

Халамж үйлчилгээ, харьцуулсан үзүүлэлтээр

Үзүүлэлт	2015 он		2016 он		Хувь	
	Хүний тоо	Олгосон тэтгэвэр, тэтгэмж	Хүний тоо	Олгосон тэтгэвэр, тэтгэмж	Хүний тоо	Олгосон тэтгэвэр, тэтгэмж
Нийгмийн халамжийн сангийн дүн	4508	1225.3	4724	1259.7	104.8	102.8
Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	1484	784.5	1526	814.5	102.8	103.8
Нийгмийн халамжийн үйлчилгээ болон хөнгөлөлт тусламж	3024	440.8	3198	445.2	105.8	101.0

Хүснэгт 1.8

Ердийн хөдөлгөөн, сумдаар, харьцуулсан үзүүлэлтээр

Сумд	Амаржсан эх			Төрсөн хүүхэд			Үрчлэгдсэн хүүхэд		
	2015 он	2016 он	Хувь	2015 он	2016 он	Хувь	2015 он	2016 он	Хувь
Баянтал	42	28	66.7	42	28	66.7	1	1	100.0
Сүмбэр	322	337	104.7	328	341	104.0	5	5	100.0
Шивээговь	71	94	132.4	71	96	135.2	1	1	100.0
Дүн	435	459	105.5	441	465	105.4	7	7	100.0

Хүснэгт 1.9

Ердийн хөдөлгөөн, сумдаар, харьцуулсан үзүүлэлтээр

Сумд	Бүртгүүлсэн гэр бүл			Цуцалсан гэр бүл			Нас баралт		
	2015 он	2016 он	Хувь	2015 он	2016 он	Хувь	2015 он	2016 он	Хувь
Баянтал	3	2	66.7	0	1		5	7	140.0
Сүмбэр	64	56	87.5	21	15	71.4	71	84	118.3
Шивээговь	11	23	209.1	3	4	133.3	14	24	171.4
Дүн	78	81	103.8	24	20	83.3	90	115	127.8

Хүснэгт 1.10

Шилжилт хөдөлгөөн, сумдаар, харьцуулсан үзүүлэлтээр

Сумд	Шилжиж ирсэн				Шилжиж явсан			
	2015 он	2016 он	Өөрчлөлт	Хувь	2015 он	2016 он	Өөрчлөлт	Хувь
Баянтал	110	79	-31	71.8	47	56	9	119.1
Сүмбэр	557	540	-17	96.9	486	530	44	109.1
Шивээговь	132	126	-6	95.5	144	101	-43	70.1
Дүн	799	745	-54	93.2	677	687	10	101.5

Хүснэгт 1.11

Нийгмийн зарим үзүүлэлтүүд, сумдаар, харьцуулсан үзүүлэлтээр

Сумд	Бүтэн өнчин хүүхэд				Хагас өнчин хүүхэд			
	2015 он	2016 он	Өөрчлөлт	Хувь	2015 он	2016 он	Өөрчлөлт	Хувь
Баянтал	1	0	-1	0.0	3	10	7	333.3
Сүмбэр	21	21	0	100.0	150	143	-7	95.3
Шивээговь	1	3	2	300.0	24	32	8	133.3
Дүн	23	24	1	104.3	177	185	8	104.5

Хүснэгт 1.12

Нийгмийн зарим үзүүлэлтүүд, сумдаар, харьцуулсан үзүүлэлтээр

Сумд	Өрх толгойлсон эцэг, эх				Хөгжлийн бэрхшээлтэй иргэд			
	2015 он	2016 он	Өөрчлөлт	Хувь	2015 он	2016 он	Өөрчлөлт	Хувь
Баянтал	37	54	17	145.9	48	53	5	110.4
Сүмбэр	577	592	15	102.6	464	466	2	100.4
Шивээговь	131	133	2	101.5	157	164	7	104.5
Дүн	745	779	34	104.6	669	683	14	102.1

Хүснэгт 1.13

Нийгмийн зарим үзүүлэлтүүд, сумдаар, харьцуулсан үзүүлэлтээр

Сумд	Ядуу өрх				Ядуу өрхийн гишүүд			
	2015 он	2016 он	Өөрчлөлт	Хувь	2015 он	2016 он	Өөрчлөлт	Хувь
Баянтал	39	54	15	138.5	155	214	59	138.1
Сүмбэр	241	242	1	100.4	1067	1072	5	100.5
Шивээговь	81	82	1	101.2	325	329	4	101.2
Дүн	361	378	17	104.7	1547	1615	68	104.4

Хүснэгт 2.1

Малтай өрх, сумдаар, төрлөөр, харьцуулсан үзүүлэлтээр

Сумд	Малтай өрх			Малчин өрх			Мал бүхий өрх		
	2015 он	2016 он	Өөрчлөлт	2015 он	2016 он	Өөрчлөлт	2015 он	2016 он	Өөрчлөлт
Баянтал	153	157	102.6	87	81	93.1	66	76	115.2
Сүмбэр	693	753	108.7	495	548	110.7	198	205	103.5
Шивээговь	148	145	98.0	91	92	101.1	57	53	93.0
Бүгд	994	1055	106.1	673	721	107.1	321	334	104.0

Хүснэгт 2.2

Малчид, сумдаар, харьцуулсан үзүүлэлтээр

Сумд	Малчид-Бүгд			Үүнээс: Эмэгтэй малчид			Малчид насны бүлгээр, 2016 он		
	2015 он	2016 он	Өөрчлөлт	2015 он	2016 он	Өөрчлөлт	15-34	35-59	60 ба түүнээс дээш
Баянтал	140	131	93.6	65	61	93.8	27	93	11
Сүмбэр	878	950	108.2	399	420	105.3	270	562	118
Шивээговь	142	150	105.6	71	77	108.5	41	85	24
Бүгд	1160	1231	106.1	535	558	104.3	338	740	153

Хүснэгт 2.3

Малын тоо, төрлөөр, харьцуулсан үзүүлэлтээр

Малын төрөл	2015 он	2016 он	Өөрчлөлт	Хувь
Адуу	18149	20250	2101	111.6
Үхэр	12390	13646	1256	110.1
Тэмээ	869	822	-47	94.6
Хонь	169090	185883	16793	109.9
Ямаа	178979	177309	-1670	99.1
Бүгд	379477	397910	18433	104.9

Хүснэгт 2.4

Малын тоо, сумаар, төрлөөр, 2016 оны жилийн эцсээр

Малын төрөл	Сумд			ДҮН
	Баянтал	Сүмбэр	Шивээговь	
Адуу	4162	14525	1563	20250
Үхэр	2094	9947	1605	13646
Тэмээ	141	572	109	822
Хонь	28374	136657	20852	185883
Ямаа	24350	133660	19299	177309
Бүгд	59121	295361	43428	397910

Хүснэгт 2.5

Төллөх насны хээлтэгч, сумдаар, харьцуулсан үзүүлэлтээр

Сумд	2015 он	2016 он	Өөрчлөлт	Хувь
Баянтал	24301	26778	2477	110.2
Сүмбэр	128966	139667	10701	108.3
Шивээговь	17921	19113	1192	106.7
Бүгд	171188	185558	14370	108.4

Хүснэгт 2.6

Мал төллөлт, сумдаар, 2016 оны жилийн эцсээр

Сумд	Төллөвөл зохих хээлтэгч	Төллөсөн хээлтэгч	Төллөлт	Гарсан төл	Хорогдсон төл	Бойжсон төл	Төл бойжилт
Баянтал	24301	24384	100.3	25340	1063	24277	95.8
Сүмбэр	128966	115955	89.9	118083	5597	112486	95.3
Шивээговь	17921	16874	94.2	16951	648	16303	96.2
Бүгд	171188	157213	91.8	160374	7308	153066	95.4

Хүснэгт 2.7

Төл бойжилт, сумдаар, харьцуулсан үзүүлэлтээр

Сумд	Гарсан төл			Хорогдсон төл			Бойжсон төл		
	2015 он	2016 он	Өөрчлөлт	2015 он	2016 он	Өөрчлөлт	2015 он	2016 он	Өөрчлөлт
Баянтал	25961	25340	97.6	156	1063	681.4	25805	24277	94.1
Сүмбэр	100140	118083	117.9	3609	5597	155.1	96531	112486	116.5
Шивээговь	17695	16951	95.8	296	648	218.9	17399	16303	93.7
Бүгд	143796	160374	111.5	4061	7308	180.0	139735	153066	109.5

Хүснэгт 2.8

Том малын зүй бус хорогдол, сумдаар, харьцуулсан үзүүлэлтээр

Сумд	Хорогдсон том мал				Оны эхний малд эзлэх хувь	
	2015 он	2016 он	Өөрчлөлт	Хувь	2015 он	2016 он
Баянтал	106	2481	2375	2340.6	0.03	4.3
Сүмбэр	1677	8650	6973	515.8	0.5	3.1
Шивээговь	204	3555	3351	1742.6	0.1	8.1
Бүгд	1987	14686	12699	739.1	0.6	3.9

Хүснэгт 2.9

Эрлийз, нутгийн шилдэг омгийн мал, сумдаар, харьцуулсан үзүүлэлтээр

Сумд	Бүгд				Үүнээс: СҮМБЭР хонь			
	2015 он	2016 он	Өөрчлөлт	Хувь	2015 он	2016 он	Өөрчлөлт	Хувь
Баянтал	7036	8613	1577	122.4			0	
Сүмбэр	2698	5025	2327	186.2	1334	1591	257	119.3
Шивээговь	90	99	9	110.0			0	
Бүгд	9824	13737	3913	139.8	1334	1591	257	119.3

Хүснэгт 2.10

Тэжээвэр амьтад, сумдаар, харьцуулсан үзүүлэлтээр

Сумд	Тахиа				Гахай			
	2015 он	2016 он	Өөрчлөлт	Хувь	2015 он	2016 он	Өөрчлөлт	Хувь
Баянтал	17	50	33	294.1	12	2	-10	16.7
Сүмбэр	2911	3732	821	128.2	283	254	-29	89.8
Шивээговь	28	11	-17	39.3	48	21	-27	43.8
Бүгд	2956	3793	837	128.3	343	277	-66	80.8

Хүснэгт 2.11

Газар тариалан, харьцуулсан үзүүлэлтээр

Үзүүлэлт		2015 он	2016 он	Өөрчлөлт	Хувь
Төмс	Тариалсан талбай, га	8.3	22.9	14.6	275.9
	Хураасан ургац, тн	49.4	97.7	48.3	197.8
Хүнсний ногоо	Тариалсан талбай, га	16.2	18.2	2	112.3
	Хураасан ургац, тн	103.1	117.4	14.3	113.9
Тэжээлийн ургамал	Тариалсан талбай, га	1.4	10.6	9.2	757.1
	Хураасан ургац, тн	3	5.1	2.1	170.0
Бүгд	Тариалсан талбай, га	25.9	51.7	25.8	199.6
	Хураасан ургац, тн	155.5	220.2	64.7	141.6

Хүснэгт 2.12

Малчдын бэлтгэсэн тэжээл, харьцуулсан үзүүлэлтээр

Үзүүлэлт	2015 он	2016 он	Өөрчлөлт	Хувь
Бэлтгэсэн өвс, тн	1775.9	1672.3	-103.6	94.2
Бэлтгэсэн дарш, тн	1.3	0.2	-1.1	15.4
Хужир шүү, тн	293.8	316.9	23.1	107.9

Хүснэгт 3.1

Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн, харьцуулсан үзүүлэлтээр

Үзүүлэлт	2015 он	2016 он	Өөрчлөлт	Хувь
Бүтээгдэхүүн үйлдвэрлэлт, сая.төг	37559.2	47063.6	9504.4	125.3
Бүтээгдэхүүн борлуулалт, сая.төг	39052.6	44724.6	5672	114.5

Хүснэгт 3.2

“Шивээ-Овоо” ХК-ий бүтээгдэхүүн, харьцуулсан үзүүлэлтээр

Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	2015 он	2016 он	Өөрчлөлт	Хувь
Бүтээгдэхүүн борлуулалт /үнийн дүнгээр/	сая.төг	37192.0	42772.1	5580.1	115.0
Нүүрс борлуулалт /биет хэмжээ/	мян.тн	1823.4	1880.3	56.9	103.1
Нүүрс гаргалт /үнийн дүнгээр/	сая.төг	35699	45111.2	9412.2	126.4
Нүүрс гаргалт /биет хэмжээ/	мян.тн	1772.9	1961.4	188.5	110.6
Ажиллагсдын тоо	хүн	515	595	80	115.5

Хүснэгт 4.1

Төсвийн орлого, харьцуулсан үзүүлэлтээр

Үзүүлэлт	2015 он			2016 он		
	Төлөвлөгөө сая.төг	Гүйцэтгэл		Төлөвлөгөө сая.төг	Гүйцэтгэл	
		сая.төг	хувь		сая.төг	хувь
Нийт орлого	15415.0	14467.0	93.9	15036.3	15701.4	104.4
Урсгал орлого	4504.8	4289.0	95.2	5034.0	5699.1	113.2
Татварын орлого	4219.8	3936.1	93.3	4289.2	4796.9	111.8
Татварын бус орлого	285.0	352.9	123.8	744.8	902.2	121.1
Хөрөнгийн орлого	0	0.7	0.0	4.0	5.9	147.5
Тусламжийн орлого	10910.2	10177.3	93.3	10002.3	10002.3	100.0

Хүснэгт 4.2

Төсвийн зарлага, харьцуулсан үзүүлэлтээр

Үзүүлэлт	2015 он			2016 он		
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	
	сая.төг	сая.төг	хувь	сая.төг	сая.төг	хувь
Бүх зарлага	16837.5	14929.2	88.7	16740.1	14687.0	87.7
Урсгал зардал	12750.7	11776.3	92.4	13587.2	12221.1	89.9
Хөрөнгийн зардал	4086.8	3152.9	77.1	3152.9	2465.9	78.2
Байгууллагын тоо	47	47	100.0	47	47	100.0
Ажиллагсдын тоо	751	751	100.0	751	751	100.0

Хүснэгт 4.3

Өглөг, авлага, харьцуулсан үзүүлэлтээр

Үзүүлэлт	2015 он	2016 он	Өөрчлөлт	Хувь
Өглөг	302.7	27.9	-274.8	9.2
Авлага	18.2	12.3	-5.9	67.6

Хүснэгт 4.4

Банк, зээл, харьцуулсан үзүүлэлтээр

Үзүүлэлт	ХЭМЖИХ НЭГЖ	2015 он	2016 он	Өөрчлөлт	Хувь
Салбар үйлчилгээний цэг	тоо	14	11.0	-3.0	78.6
Цахим банкны үйлчилгээний хэрэглэгчид	хүн	17046	22080	5034.0	129.5
Зээлийн бүтээгдэхүүн	тоо	76	52	-24.0	68.4
Зээл авсан : ААНБ	тоо	31	20	-11.0	64.5
Иргэд	хүн	7958	7749	-209.0	97.4
Малчид	хүн	365	546	181.0	149.6
Зээл олгосон : ААНБ	сая.төг	1590.9	1811.6	220.7	113.9
Иргэд	сая.төг	34541.3	70473.0	35931.7	204.0
Малчид	сая.төг	1511.0	4435.4	2924.4	293.5
АТМ-н тоо	тоо	9	11	2.0	122.2

Хүснэгт 4.5

Бараа, ажил үйлчилгээ, харьцуулсан үзүүлэлтээр

Үзүүлэлт	2015 он	2016 он	Өөрчлөлт	Хувь
Төлөвлөгдсөн бараа үйлчилгээ	71	51	-20	71.8
Зарлагдсан тендер	59	51	-8	86.4
Төлөвлөсөн төсөв /сая.төг/	3805.6	2066.9	-1738.7	54.3
Гэрээлэгдсэн төсөв /сая.төг/	2653.7	1832.5	-821.2	69.1

Хүснэгт 5.1

Нийгмийн даатгалын орлого, зарлага, харьцуулсан үзүүлэлтээр

Үзүүлэлт	2015 он	2016 он	Өөрчлөлт	Хувь
Нийгмийн даатгалын сангийн орлого, сая.төг	6685.1	7583.6	898.5	113.4
Тэтгэврийн даатгалын сангийн	4436.5	4747.9	311.4	107.0
Тэтгэмжийн даатгалын сангийн	425.7	527.1	101.4	123.8
Эрүүл мэндийн даатгалын сангийн	1177.6	1414.3	236.7	120.1
ҮОМШӨ-ний даатгалын сангийн	526.6	736.9	210.3	139.9
Ажилгүйдлийн даатгалын сангийн	118.8	157.5	38.7	132.6
Нийгмийн даатгалын сангийн зарлага, сая.төг	8600.6	9385.3	784.7	109.1
Тэтгэврийн даатгалын сангийн	6146.3	6781.5	635.2	110.3
Тэтгэмжийн даатгалын сангийн	591.9	569.5	-22.4	96.2
Эрүүл мэндийн даатгалын сангийн	1349.3	1527.6	178.3	113.2
ҮОМШӨ-ний даатгалын сангийн	312.5	287.5	-25	92.0
Ажилгүйдлийн даатгалын сангийн	200.6	219.2	18.6	109.3

Хүснэгт 5.2

Даатгал, нөхөн төлбөр, харьцуулсан үзүүлэлтээр

Үзүүлэлт	2015 он		2016 он		Өөрчлөлт		Хувь	
	Орлого /мян.төг/	Олгосон нөхөн төлбөр /мян.төг/ /	Орлого /мян.төг/	Олгосон нөхөн төлбөр /мян.төг/ /	Орлого /мян.төг /	Олгосон нөхөн төлбөр /мян.төг /	Орлого	Олгосон нөхөн төлбөр
Тээврийн хэрэгслийн даатгал	50131.4	17504.2	28459.0	31705.2	21672.4	14201.0	56.8	181.1
Жолоочийн хариуцлагын даатгал	93964.9	51409.5	108578.0	19163.0	14613.1	32246.5	115.6	37.3
Эд хөрөнгийн даатгал	1556.8	1278.0	1241.0	0.0	-315.8	-1278.0	79.7	0.0
Хөдөлмөрийн чадвар түр алдалтын даатгал	0.0	0.0	17971.2	12398.0	17971.2	12398.0	*	*
Гэнэтийн ослын даатгал	15411.1	4114.0	20791.0	2424.0	5379.9	-1690.0	134.9	58.9
Хүүхдийн гэнэтийн ослын даатгал	30.0	149.4	2244.0	271.2	2214.0	121.8	7480.0	181.5
Гадаад зорчигчдын даатгал	47.1	0.0	148.4	0.0	101.3	0.0	315.1	*
Мэргэжлийн хариуцлагын даатгал	834.0	0.0	1062.8	2380.0	228.8	2380.0	127.4	*
Ачаа тээвэрлэлтийн даатгал	6247.1	0.0	2803.4	0.0	-3443.7	0.0	44.9	*
Гэр хашаа байшингийн даатгал	0.0	0.0	375.0	127.0	375.0	127.0	*	*
Эрүүл мэндийн даатгал	22804.2	13953.0	0.0	0.0	22804.2	13953.0	0.0	0.0
Дүн	191026.6	88408.1	183673.8	68468.4	-7352.8	19939.7	96.2	77.4
Банкны зуучлалаар хийгдсэн даатгал	13067.3	701.6	28539.6	323.3	15472.3	-378.3	218.4	46.1
Бүгд	204093.9	89109.7	212213.4	68791.7	8119.5	20318.0	104.0	77.2

Хүснэгт 6.1

Тээвэр зуучлал, харьцуулсан үзүүлэлтээр

Үзүүлэлт	ХЭМЖИХ НЭГЖ	2015 он	2016 он	Өөрчлөлт	Хувь
Зорчигч эргэлт	мян.хүн.км	5304.0	5355.2	51.2	101.0
Тээвэрлэсэн зорчигч	мян.хүн	22.1	23.9	1.8	108.0
Тээврийн орлого	мян.төг	12112.1	14200	2087.9	117.2
Ажиллагчдын тоо	хүн	10	11	1.0	110.0

Хүснэгт 6.2

Тээврийн хэрэгсэл, харьцуулсан үзүүлэлтээр

Төрөл	2015 он	2016 он	Өөрчлөлт	Хувь
Суудлын автомашин	1719	1759	40	102.3
Ачааны автомашин	753	838	85	111.3
Хоёр дугуйт	202	207	5	102.5
Бусад	777	243	-534	31.3
Бүгд	3451	3047	-404	88.3

Хүснэгт 6.3

Харилцаа холбоо, харьцуулсан үзүүлэлтээр

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2015 он	2016 он	Өөрчлөлт	Хувь
Нийт орлого	мян.төг	220165.1	202478	-17687.1	92.0
Үүнээс: Хүн амаас	мян.төг	121529.6	121583.6	54.0	100.0
КАТВ-ийн сувагт холбогдсон хэрэглэгч	тоо	1272	1233	-39.0	96.9
Телефон цэг	тоо	398	334	-64.0	83.9

Хүснэгт 6.4

Газрын нэгдмэл сан, харьцуулсан үзүүлэлтээр

Газрын ангилал	2015 он	2016 он	Өөрчлөлт	Хувь
Нийт газар, га	554180.0	554180.0	0	100.00
Хөдөө аж ахуйн газар	481828.4	481694.0	-134.4	99.97
Хот, тосгон бусад суурин газар	6037.7	6168.6	130.9	102.17
Зам, шугам сүлжээний газар	5114.1	5117.6	3.5	100.07
Усны сан бүхий газар	1538.0	1538.0	0	100.00
Улсын тусгай хэрэгцээний газар	59661.8	59661.8	0	100.00

Хүснэгт 6.5

Газарт учирсан хохирол, хувиар, харьцуулсан үзүүлэлтээр

Газрын ангилал	2015 он	2016 он	Өөрчлөлт, пункт
Хохирол учирсан талбайн нийт газарт эзлэх хувь	1.8	0.9	-0.9
Хохирол учирсан талбай	100.0	100.0	0
Бэлчээр ба бусад суурин газарт	94.8	94.2	-0.6
Хот, тосгон бусад суурин газарт	4.6	5.0	0.4
Үүнээс: Усны сан бүхий газар	0.3	0.7	0.4
Ухаж эвдэрсэн газарт	0.3	0.1	-0.2

Хүснэгт 7.1

Сургуулийн өмнөх боловсролын бүлэг, хамрагдалт, харьцуулсан үзүүлэлтээр

Үзүүлэлт	2015-2016	2016-2017	Өөрчлөлт	Хувь
Нийт цэцэрлэг	9	9	0	100.0
Төрийн	5	5	0	100.0
Хувийн	4	4	0	100.0
Цэцэрлэгт хамрагдсан хүүхэд	1585	1652	67	104.2
Эмэгтэй хүүхэд	756	797	41	105.4
Малчдын хүүхэд	199	151	-48	75.9
Цэцэрлэгийн бүлэг	49	49	0	100.0
Яслийн бүлэг	1	0	-1	0.0
Бага бүлэг	13	12	-1	92.3
Дунд бүлэг	7	10	3	142.9
Ахлах бүлэг	8	8	0	100.0
Бэлтгэл бүлэг	9	10	1	111.1
Холимог бүлэг	4	3	-1	75.0
Ээлжийн бүлэг	3	1	-2	33.3
Нүүдлийн бүлэг	4	5	1	125.0

Хүснэгт 7.2

Сургуулийн өмнөх боловсролд ажиллагсад, харьцуулсан үзүүлэлтээр

Үзүүлэлт	2015-2016	2016-2017	Өөрчлөлт	Хувь
Нийт ажиллагсад	162	161	0	99.4
Эрхлэгч	9	9	0	100.0
Арга зүйч	1	1	0	100.0
Үндсэн багш	46	47	1	102.2
Туслах багш	41	42	1	102.4
Эмч	2	2	0	100.0
Бусад ажиллагсад	63	60	-3	95.2

Хүснэгт 7.3

Ерөнхий боловсролын сургуулийн бүлэг, хамрагдалт, харьцуулсан үзүүлэлтээр

Үзүүлэлт	2015-2016	2016-2017	Өөрчлөлт	Хувь
Нийт сургууль	5	5	0	100.0
Нийт сураглцагсад	3301	3340	39	101.2
Эмэгтэй	1681	1717	36	102.1
Малчдын хүүхэд	515	552	37	107.2
Сургуулийн бүлэг	121	122	1	100.8
1-5 дугаар анги				
бүлэг	59	60	1	101.7
суралцагсад	1667	1740	73	104.4
6-9 дүгээр анги				
бүлэг	32	40	8	125.0
суралцагсад	836	1026	190	122.7
10-12 дугаар анги				
бүлэг	30	22	-8	73.3
суралцагсад	798	574	-224	71.9
<u>Дотуур байранд амьдарч буй хүүхэд</u>	135	165	30	122.2

Хүснэгт 7.4

Ерөнхий боловсролын сургуульд ажиллагсад, харьцуулсан үзүүлэлтээр

Үзүүлэлт	2015-2016	2016-2017	Өөрчлөлт	Хувь
Нийт ажиллагсад	273	275	0	100.7
Захирал	5	5	0	100.0
Сургалтын менежер	9	9	0	100.0
Нийгмийн ажилтан	5	4	-1	80.0
Үндсэн багш	179	181	2	101.1
Эмч	5	5	0	100.0
Бусад ажиллагсад	70	71	1	101.4

Хүснэгт 8.1

Эрүүл мэндийн статистик, харьцуулсан үзүүлэлтээр

Үзүүлэлт	2015 он	2016 он	Өөрчлөлт	Хувь
Төрсөн эх	442	446	4	100.9
Амьд төрсөн хүүхэд	446	450	4	100.9
Амьгүй төрсөн хүүхэд	2	2	0	100.0
Нялхсын эндэгдэл	6	7	1	116.7
5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл	7	9	2	128.6
Нийт нас баралт	81	73	-8	90.1
Эмчлэгдсэн өвчтөн	4568	5023	455	110.0
Түргэн тусламжийн дуудлага	6791	6927	136	102.0
Амбулаторын үзлэг	119733	122060	2327	101.9
Халдварт өвчин	115	292	177	253.9

Хүснэгт 9.1

Гэмт хэргийн статистик, харьцуулсан үзүүлэлтээр

Үзүүлэлт	2015 он	2016 он	Өөрчлөлт	Хувь
Хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг	92	91	-1	98.9
Хүүхэд гэр бүлийн нийгмийн ёс суртахууны эсрэг гэмт хэрэг	4	7	3	175.0
Иргэдийн улс төрийн болон эрх чөлөөний эсрэг гэмт хэрэг	1	1	0	100.0
Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг	74	73	-1	98.6
Аж ахуйн эсрэг гэмт хэрэг	0	1	1	***
Нийгмийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг	13	9	-4	69.2
Хүн амын эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг	1	8	7	800.0
Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг	19	13	-6	68.4
Захиргааны журмын эсрэг гэмт хэрэг	6	0	-6	0.0
Шүүн таслах ажиллагааны эсрэг гэмт хэрэг	1	2	1	200.0
Албан тушаалын гэмт хэрэг	0	2	2	***
Бүгд	211	207	-4	98.1